

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын
2017оны үйл ажиллагааны үр дүн”

2018 он

Уг тайланг WWW.AUDIT.MN сайтаас үзнэ үү.

Аудитын тайлан, дүгнэлттэй
холбоотой асуудлаар нэмж
тодруулах, асууж лавлах зүйл
байвал 70463783 ,
ордон 70463612 дугаарын 309, 310 тоот өрөө
утсаар харилцана уу

ХАЯГ: Завхан аймаг дахь
Төрийн аудитын газар
Улиастай сум, Жинст багийн
Нутгийн захиргааны

Гүйцэтгэсэн :
Ахлах аудитор
Ч.Бямбасүрэн
Аудитор
Б.Мөнхнасан

Хянасан:

Дарга бөгөөд Тэргүлэх
аудитор Л.Уламбаяр
Аудитын менежер
Г.Хашцэцэг

2018.05.04

УЛИАСТАЙ ХОТ

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар.....	3
Аудитхийх үндэслэл, аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	4-5
ГБХЗХГ-нь үйл ажиллагааны төлөвлөгөөндөө хуулиар хүлээсэн үүргээ бүрэн тусгаж, зорилго зорилтоо үнэн зөв тодорхойлжээ.....	5- 11
Дугуйлангийн хүүхдүүдийн төлбөрийг данс, бүртгэлээр дамжуулахгүй төвлөрүүлэн зарцуулж байна.....	11-16
Сахиулын цалинг Монгол улсын Засгийн газрын 2007 оны 12 сарын 26-ны өдрийн 354 тоот тогтоолын дагуу зөв тогтоогоогүй байна.....	16
Хөрөнгийн хадгалалт хамгаалалт, ашиглалт, эмх цэгц сайн дутагдсан хөрөнгө байхгүй байна.....	16-17
Зөвлөмж	18

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

- НББ- Нягтлан бодох бүртгэл
- АИТХ- Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
- БСУГ-Боловсрол соёл урлагийн газар
- ХХҮГ- Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар
- АХНЗ- Аймгийн хүүхдийн нэгдсэн зөвлөл
- ЕБС- Ерөнхий боловсролын сургууль
- ТББ- Төрийн бус байгууллага
- ГБХЗХГ- Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
- НҮБ- Нэгдсэн үнэдсний байгууллага
- ХНХЯ- Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ,АРГА ЗҮЙ

Аудит хийх үндэслэл,бүрэн эрх

Монгол Улсын Ерөнхий аудитор 2018 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөө, Завхан аймаг дахь төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийв.

1. Аудитын зорилт

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2017 онд дэвшүүлсэн зорилго, зорилт, үйл ажиллагааны орлого бүрдүүлэлт, зарцуулалт, дамжин хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөр, хөрөнгө оруулалтын ажил, орон тоо, цалин тогтоолт, боловсон хүчнийг хэрхэн сонгож томилж байгаа байдал, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, төсөл хөтөлбөр хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн хөрөнгийг орлогод бүрэн авч, хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг хангаж байгаа эсэхэд аудит хийж, дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- ❖ Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар нь 2017 онд дэвшүүлсэн зорилго, зорилтоо бүрэн биелүүлсэн эсэх.
- ❖ Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2017 оны орлого бүрдүүлэлт, зарцуулалт,хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөр, хөрөнгө оруулалтын ажлын үр дүнгийн талаар
- ❖ Орон тоо, цалин тогтоолт, боловсон хүчнийг хэрхэн сонгож томилж байгаа байдал
- ❖ Хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, төсөл хөтөлбөр, хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн хөрөнгийг орлогод бүрэн авч, хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг хангаж байгаа эсэх

2. Аудитын хамрах хүрээ

Аудитаар тус байгууллагын 2017 оны үйл ажиллагааны тайлан, орлого бүрдүүлэлт,зарцуулалтын байдал, санхүүжүүлсэн хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, орон тоо, хөрөнгийн худалдан авалт,ашиглалт, хамгаалалттай танилцаж, бусад холбогдох баримт материал, бүртгэл тайлан мэдээг хамруулав.

3. Аудитын арга зүй

Аудитын явцад асуудлыг шинжлэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан, холбогдох албан тушаалтан нартай

ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, санхүүгийн болон ажлын тайланг судлах, нөхцөл байдлын шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ аудитын хөтөлбөр болон аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж,үйл ажиллагаанд дүгнэлт өгч зорилго зөвлөмж боловсруулсан болно.

Мөрдөж буй хууль, дүрэм, журам, гэрээний биелэлтийг шалгаж, нөхцөл байдлыг судлан байгууллага, иргэдээс мэдээлэл авч түүвэрчлэн судалгаа хийхийн зэрэгцээ гарсан зөрчил дутагдлыг нотлох баримтаар баталгаажуулан гүйцэтгэсэн болно.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт

Дараах хууль эрхзүйн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглалаа. Үүнд:

- Төрийн хяналт шалгалтын стандарт
- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Хүүхдийн эрхийн тухай хууль
- Хүүхэд хамгааллын тухай хууль
- Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль
- Гэр бүлийн тухай хууль
- Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль
- Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын НББ-ийн бодлогын баримт бичиг болон холбогдох бусад хууль, журам, эрхийн актууд болно.

4. Аудит хийсэн бүрэлдэхүүн, хугацаа

Аудитыг аудитын менежер Г.Хашцэцэг хянан удирдаж, Ахлах аудитор

Ч.Бямбасүрэн, аудитор Б. Мөнхнасан нар 2018 оны 04 дүгээр сарын 06-наас эхлэн 05 сарын 14-ний өдрийг хүртэл хугацаанд хийж гүйцэтгэлээ.

6.Аудитын дүн, тайлан баталгаажуулалт:

Аудитын тайлан нь ерөнхий зүйл, аудитын дүн, дүгнэлт, холбогдох байгууллагын санал, аудитын зөвлөмж, болон хавсралт хэсгүүдээс бүрдэнэ.

Аудитын тайлангийн төслийг 2018 оны 05 дугаар сарын 02 –ны өдрөөс 05 сарын 09-ний өдрүүдэд боловсруулж,төслийг ГБХЗХГ-т санал авахаар 2018 оны 05 сарын 11-ны өдөр хүргүүлэн, саналыг авлаа.

Аудитын тайланг 05 дугаар сарын 14-ний өдөр эцэслэн боловсруулж, удирдах зөвлөлийн хуралд оруулан, АИТХ-дболон тухайн байгууллагадхүргүүлэв.

Бүлэг 1. Тус байгууллага нь үйл ажиллагааны төлөвлөгөөндөө хуулиар хүлээсэн үүргээ бүрэн тусгасан боловч, асуудлыг жижигрүүлж задалсан, хэт нурушсан, хэрэгжих боломжгүй буюу хөрөнгө эх үүсвэр нь тодорхой биш, утга санаа давхардсан ажил үйлчилгээг тусгасан дутагдал байна.

Тус байгууллага нь 2017 онд гэр бүлийн тулгуур үнэт зүйлд суурилсан хүүхэд, залуучуудын манлайлал-хөгжил, оролцоог нэмэгдүүлэх, бат бэх хариуцлагатай гэр бүлийг бий болгох, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх, эрхийг хангах, хамгааллыг бэхжүүлэх цогц бодлогыг хэрэгжүүлэх гэсэн зорилгын хүрээнд дараах 5 зорилт дэвшүүлэн ажиллажээ.

- Гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудлаарх бодлогын хэрэгжилтийг хангах, салбар дундын удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах
- Гэр бүлийн боловсрол, үнэт зүйл хариуцлагыг нэмэгдүүлж, хүчирхийлэлгүй, бат бэх, эрүүл гэр бүлийг төлөвшүүлэх
- Хүүхдийг аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалал шаардагатай хүүхдэд үзүүлэх үйлчилгээг сайжруулж, нийгэмшихүйн хөгжлийг дэмжих
- Залуучуудын манлайлал, хариуцлагыг бий болгох, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, дэмжих бүлэг, сонирхлын зөв нэгдлийг дэмжиж, амьдрах ухааны боловсролыг олгох.
- Үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитыг төлөвшүүлж, ажилтан, албан хаагчдын хариуцлагыг өндөржүүлж, байгууллагын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилт дэвшүүлжээ.

Эдгээр зорилтууд нь үйл ажиллагааны цар хүрээг бүхэлд хамарсан байна.

Үйл ажиллагааны төлөвлөгөөнд бусад төсөл хөтөлбөрийн байгууллага хариуцан хэрэгжүүлэхээр 4 арга хэмжээ, төсөл хөтөлбөр, өмнөх оны гэрээнээс биелэгдээгүй үлдсэн, гүйцэтгэл нь 2018 онд биелэгдэх 2 төрлийн хөтөлбөр, арга хэмжээнүүдийг тусгаж, 2017 онд дэвшүүлсэн зорилтуудаар ангилсан байна.

Хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн арга хэмжээ, төсөл хөтөлбөрүүдэд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан чиг үүргүүдээс 11 арга хэмжээ, Хүүхдийн эрхийн тухай хуулинд тусгагдсан чиг үүргүүдээс 38 арга хэмжээ, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуульд заасан чиг үүргүүдээс 12 арга хэмжээ, Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан чиг үүргүүдээс 9 хэмжээ, Хүүхэд харах үйлчилгээний тухай хуульд заасан чиг үүргүүдээс 3 арга хэмжээ тусгасан байна. Үүнээс гадна Аймгийн үндсэн чиглэл, Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсан чиг үүргүүдээс 12 арга хэмжээ, ХНХЯ-ны сайдтай байгуулсан гэрээнд тусгагдсан чиг үүргүүдээс 3 арга хэмжээг тус тус тусгажээ.

Нэгдүгээр зорилтын хүрээнд 23 арга хэмжээ, хоёрдугаар зорилтын хүрээнд 14 арга хэмжээ, гуравдугаар зорилтын хүрээнд 21 арга хэмжээ, дөрөвдүгээр зорилтын хүрээнд 12 арга хэмжээ, тавдугаар зорилтын хүрээнд 15 арга хэмжээ нийт 85 хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажилласан байна.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын Аймгийн засаг даргатай байгуулсан 2017 оны үр дүнгийн гэрээний биелэлтийг хүснэгтээр харуулбал:

Зорилт	ХЭРЭГЖИЛТ						Нэгдсэн дүн /хувиар/
	Тоогоор	Хувиар					
		100%	70%	30%	0%	Хугацаа болоогүй /тоо/	
Байгууллагын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт	88	54	21	12	1		80,2%
Тусгай захиалгат бүтээгдэхүүний биелэлт	7	2	5	0	0		78.5%
Манлайлалын зорилт	5	3	2	0	0		88%
Мэдлэг чадвар дээшлүүлэх	2	2	0	0	0		100%
Ерөнхий дүн	102	56	33	12	1		86.6%

Хэрэгжилт нь 70 хувиар дүгнэгдсэн 21 ажил үйлчилгээг тодруулахад үе шаттайгаар дараагийн жилүүдэд хэрэгжих буюу тодорхой шалтгааны улмаас гүйцэтгэл, үр дүн нь бүрэн гараагүй арга хэмжээнүүд байна.

Харин хэрэгжилт нь 30 хувиар дүгнэгдсэн 12 ажил үйлчилгээний хувьд хэрэгжих боломжгүй буюу хөрөнгө санхүүтэй холбоотой ажил үйлчилгээ төлөвлөсөнтэй холбоотой байна. Тухайлбал:

- ✓ Газрын стратеги, бүтэц орон тооны өөрчлөлтийн завсрын хөтөлбөр боловсруулж, мөрдөх
- ✓ Аймгийн Засаг даргын дэргэдэх Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дүрэм, бүтэц, орон тоог боловсруулан, хэрэгжүүлэх

- ✓ Залуучуудын хөгжлийг дэмжих Аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх, үйл ажиллагааны төлөвлөлтийг шинэчлэн боловсруулах
- ✓ Залуучуудын хөгжлийн төвийн “Интернет танхим”-ын үйл ажиллагааны хэвийн нөхцлийг хангах гэх зэрэг хөрөнгө, санхүү, бүтэц орон тоотой холбоотой асуудлууд байна.

Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2017 оны ажлын төлөвлөгөөнд тусгасан “Залуучуудын хөгжлийг дэмжих Аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөлтийг шинэчлэн боловсруулах ажил хийгдээгүй байгаа нь Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль батлагдсантай холбоотой хууль дүрэмтэй нийцүүлэн бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулах болсонтой холбоотой байна.

Аудитын явцад хэрэгжсэн арга хэмжээ, ажил үйлчилгээг анхан шатны суурь судалгаа болон хийгдсэн ажлуудын тайлангуудтай тулгахад дээрх үнэлгээ бодитой байна гэж үзлээ.

Тус байгууллагын 2017 онд гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудлаарх бодлогын хэрэгжилтийг хангах, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх, хүүхдийн эрхийг хангах, хамгааллыг бэхжүүлэх цогц бодлогыг хэрэгжүүлэх, залуучуудын хөгжлийг дэмжих, оролцоог нэмэгдүүлэх, бат бэх хариуцлагатай гэр бүлийг бий болгох, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр хэрэгжүүлсэн үр нөлөөтэй зарим арга хэмжээнүүдээс дурьдвал:

1. Гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудлаарх бодлогын хэрэгжилтийг хангах, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх, хүүхдийн эрхийг хангах, хамгааллыг бэхжүүлэх цогц бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр

- “Хүүхдэд ээлтэй орон нутаг” хөтөлбөр эхний шатандаа хэрэгжиж эхэлсэн
- Аймгийн “Хүүхдийн төлөө” зөвлөлийг аймаг болон сумдад шинэчлэн байгуулж, анхдугаар хуралдааныг зохион байгуулж үйл ажиллагааг тогтмолжуулсан.
- Аймгийн Засаг даргын Хууль, эрх зүйн хэлтсийн даргаар ахлуулан, Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга, Шүүхийн тамгын газрын дарга, Ерөнхий прокурор, Цагдаагийн газрын дарга, БСУГ-ын дарга, ХХҮГ-ын дарга ЭМГ-ын дарга, Хууль зүйн туслалцааны төвийн Завхан салбарын ахлах улсын өмгөөлөгч зэрэг 11 хүний бүрэлдэхүүнтэй хүүхдийн эрхийн хууль зүйн хороог байгуулан хамтран үйл ажиллагаагаа уялдуулан ажилласан.
- Залуучуудын хөгжлийн тухай шинэ хуулийг залуучуудын өдрөөр залуус эрүүл мэндийнхээ төлөө юу хийж чадах вэ арга хэмжээгээр дамжуулж 710 залууст суртачилан таниулсан байна.

- Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын хэлэлцүүлэг болон шинээр батлагдсан гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг 1021 гэр бүлд танилцуулан сургалт суртачилгаа хийсэн.
- Хүүхдийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг хянах, мэдээллийн сангийн программыг нэвтрүүлэн, ашиглах алхмууд хийгдэж эхэлсэн байна.
- Хамтарсан багийг чадавхжуулах сургалт зохион байгуулагдаж 240 хүн хамрагдсан байна. / зураг/



- “Хүүхдээ сонсьё” хөдөлгөөний хүрээнд ЕБС-ийн сурагчдын дунд эссэ бичлэг, гар зураг, шүлгийн уралдаан зохион байгуулсан. Мөн сургууль болгон дээр саналын хайрцагтай болж АХНЗ-ийн хүүхдүүдээр дамжуулан хүүхдийн дуу хоолойг сонсдог болсон.
- “Хүүхдээс хүүхдэд” чиглэсэн аргачлалыг түгээх, бодит нөхцөлд үндэслэн тооцоо, судалгаа бүхий төлөвлөлтийг хийх, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох зорилгоор хэлэлцүүлэг хийсэн. / зураг/



2. Залуучуудын хөгжлийг дэмжих, оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр

- Аймгийн 15-34, 0-18 насны залуучуудын тоон мэдээллийн суурь судалгаа болон “Залуучуудын хөгжил-2017 судалгааг гаргасан.
- Залуучуудын хөгжлийн төвийн хэвийн үйл ажиллагааг хангаж, залуучуудын зөвлөлийг идэвхжүүлэн ажиллах зорилгоор 5 төрлийн сургалтанд хамрагдаж, нөлөөллийн ажлыг суртачилах суртачилгааны ажлыг зохион байгуулсан.
- Z-Y-PEER клубтэй хамтран “Мэдлэгээ хэрэглээ болгоё” аяны хүрээнд 15-17 насны 108 оюутан суралцагсадыг хамруулан үерхэл, нөхөрлөл, хайр дурлалын үнэ цэнэ, утга учрын талаар лекц, БЗДХөвчний талаарх ойлголт нэмэгдүүлэх багц мэдээллийн сургалт, танин мэдэхүйн АХА тэмцээн зохион байгуулсан.



- ТББ болон төсөл хөтөлбөрийн байгууллагатай хамтран ажиллаж 3-н дэмжих бүлгийн тогтвортой байдлыг хангахад арга зүйн дэмжлэг үзүүлсэн.
- Амьдрах ухааны боловсрол олгох модуль сургалтыг 147 залуучуудыг хамруулан зохион байгуулсан.
- “Залуучуудын гарааны бизнесийг дэмжих” хөтөлбөрт 90 өсвөр үе, залуучуудыг хамруулж, төсөл бичих арга аргачлалд сургасан байна.

3. Бат бэх хариуцлагатай гэр бүлийг бий болгох, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр:

- Аз жаргалтай гэр бүл хүний хөгжлийн анхдагч орчин хөдөлгөөний хүрээнд сургалт, суртачилгаа, арга хэмжээнүүдийг 8-н удаа зохион байгуулсан байна.
- Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын хэлэлцүүлгийг 3-н удаа зохион байгуулсан.
- Гэр бүлийн боловсрол олгох, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд 97-н гэр бүлийн 411 хүнд сургалт зохион байгуулсан байна.

Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн газар нь Аймгийн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэст 2017 оны 09 сарын 15 ны 87 тоот албан бичгээр үйл ажиллагааны тайланд тусгагдсан ажил үйлчилгээний хэрэгжилтийн явц, байдлыг, 2017 оны 12 сарын 28-нд 190 тоот албан бичгээр Аймгийн засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт, үйл ажиллагааны бичмэл тайлан, байгууллагын үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангуудыг илтгэх хуудсаар тус тус хүргүүлжээ.

Аймгийн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс нь ГБХЗХГ-ын гэрээний хэрэгжилт, биелэлтийг бүрэн хянаагүй, эхний хагаст шалгуур үзүүлэлтийн зорилтот түвшиний 30 хүртэл хувийг хангаагүй, жилийн эцсийн үнэлгээгээр санхүүгийн эх үүсвэргүй нь тогтоогдсон, үр дүнгүй, үнэлэх боломжгүй гэж үзсэн зорилт, арга хэмжээг цаашид үргэлжлүүлэх саналыг хүргүүлээгүй байна.

Мөн гэрээ байгуулсан талууд явц байдлын талаар хэлэлцэж, холбогдох арга хэмжээг аваагүй нь үр дүнгийн гэрээний дүгнэлтэд нөлөөлсөн байна.

ДҮГНЭЛТ: Цаашид үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргахдаа холбогдох хуулинд заасан үүрэг, оролцоог үндэслэн, хэрэгжих боломжтой үр нөлөөтэй ажил үйлчилгээг тодорхой онож тусгах шаардлагатай байна гэж үзлээ.

Бүлэг 2. Дугуйлангийн хүүхдүүдийн төлбөрийг данс, бүртгэлээр дамжуулахгүй төвлөрүүлэн зарцуулж байна.

2.1. 2017 оны орлого бүрдүүлэлтийн байдлыг графикаар харуулбал:



2017 онд батлагдсан санхүүжилтээ бүрэн авч, нэмэлт санхүүжилтээрХөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас “Гэр бүл хүүхэд залуучуудын газар” ТББ-аас хүүхэд харах үйлчилгээний санхүүжилтээр 115540,1мянган төгрөгийнбусад төсөл хөтөлбөрөөр 118359,9 мянган төгрөгийн,нийт 392800,0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлэн ажилласан байна.

Төсөл хөтөлбөрөөр ХНХЯ-аас залуучуудын хөгжлийн төвийн ажилчдын цалин, үйл ажиллагааны зардалд 28200,0 мянган төгрөгийн, баруун бүсийн ГБХЗХГ-ын ажилтанг мэргэшүүлэн чадавхжуулах сургалт,хэлэлцүүлэгийн зардалд 12000,0 мянган төгрөгийн,НҮБ-ын хүүхдийн сангаас хамтарсан багийн сургалтын зардалд 43200,0 мянган төгрөгийн,ГБХЗХГазар ТББ-аас залуучуудын нөлөөллийн ажлын сургалт, суртачилгааны зардалд 35000,0 мянган төгрөгийн санхүүжилтийг тус тус авсан байна.

Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар нь 2017 онд хүүхэд залуучуудын дунд шатар, ширээний теннис, бүжгийн дугуйлангууд хичээллүүлдэг бөгөөд эдгээрээс бүжгийн дугуйлангийн үйл ажиллагаа тогтмол хичээллэж байна.

Бүжгийн дугуйланд 30 хүүхэд тогтмол суралцдаг учир төлбөр тогтмол төвлөрдөг, харин теннис, шатрын дугуйлан нь багш- байгууллага-суралцагчдын хоорондын ойлголцол, төлбөр, мөнгөнөөс шалтгаалан тогтмол хичээллэдэггүй учир орлого тогтмол төвөрдөггүй байна.

2017 онд бүжгийн дугуйлангийн суралцагчдын сургалтын төлбөрийн 1950,0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэнийг бүртгэлд тусгалгүйгээр багш нарын ажлын хөлсөнд зарцуулсан дутагдал илэрлээ.

2.2 Тус байгууллага нь тайлант хугацаанд 392800,0 мянган төгрөгийн зарлагатай, төсвийн хэтрэлт хэмнэлт гаргаагүй ажилласан байна.

Зардлын зүйлийг эдийн засгийн ангилалаар нь авч үзэхэд:

д/д	Зардлын зүйл	Төлөвлөгө ө	Гүйцэтгэл	Хэтрэлт	Хэмнэлт
1	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	89800,0	87733,0		2067,0
2	НДШ	9878,0	11944,9	-2067,0	
3	Гэрэл цахилгаан	2020,9	1765,9		255,0
4	Түлш халаалт	43566,5	43946,0	-379,5	
5	Цэвэр бохир ус	940,9	816,4		124,5
6	Бичиг хэрэг	1646,4	1848,7	-202,3	
7	Тээвэр шатахуун	1342,9	1342,9		
8	Шуудан холбоо	739,6	739,6		
9	Урсгал засвар	286,1	331,6	-45,5	
10	Томилолт	1662,2	1662,2		
11	Мэдээлэл технологийн зардал	428,9	383,4		45,5

12	Хичээл үйлдвэрлэлийн дадлага	3291,7	3089,4		202,3
13	Нэг удаагийн тэтгэмж		3300,0	-3300,0	

Хэтэрсэн болон хэмнэгдсэн зардлууд нь дараах шалтгаантай байна.

- Цалингийн зардал 2067,0 мянган төгрөгөөр хэмнэсэн шалтгаан нь 1 албан хаагч жирэмсний амралт авч, түүний орон тоонд хүн авч ажиллуулаагүй бусад албан хаагч хавсран гүйцэтгэсэнтэй холбоотой байна.
- НДШ-ийн зардлыг 2067,0 мянган төгрөгөөр хэтрүүлсэн шалтгаан нь жирэмсний амралттай албан хаагчийн шимтгэл төлсөн бөгөөд, 806,0төгрөгийг авлага үүсгэн илүү шилжүүлсэнтэй холбоотой байна.
- Түлш халаалтын зардал 379,5 мянган төгрөгөөр хэтэрсэн, 4893,9 мянган төгрөгийн өр үүссэн шалтгаан нь төсөв дутуу батлагдсантай холбоотой байна.
- Бичиг хэргийн зардал 202,3 мянган төгрөгөөр хэтэрсэн нь, хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардлаас бичиг хэргийн материалыг худалдан авсантай холбоотой байна.
- Нэг удаагийн тэтгэмжийн зардал хэтэрсэн шалтгаан нь албан хаагч тус бүрд төрийн албан хаагчийн урамшил300,0 мянган төгрөг олгосныг төсөвт төлөвлөж өгөөгүйтэй холбоотой байна.

Аудитаар төсвийн зарцуулалттай холбоотой дараах зөрчил илрүүллээ.

- Жолоочийн замын хуудсаарх тооцоог бодоогүй, автомашины шатахуун зарцуулалтын хэтрэлт хэмнэлтийг тооцдоггүй, шатахуун зарцуулалтад бүртгэлээр тавих хяналт сул байна.
- Бүжгийн дугуйлангийн сурагчдын сургалтын төлбөрийн 1950,0 мянган төгрөгийг бүртгэлд тусгалгүйгээр зарцуулсан байна.
- Ажил олгогчоос төлөх шимтгэлийг хуульд заасан хувиас илүү шилжүүлж 806,0 мянган төгрөгийн авлага үүсгэсэн.
- Ажиллагсдын амралтын цалин бодохдоо ажилчдад олгосон хоол, унааны хөнгөлөлтийг хасалгүйгээр бодож 636,4 мянган төгрөгийг илүү олгосон. / жагсаалтаар хавсаргав./
- Томилолтоор ажилласан 4 албан хаагчдад 108,0 мянган төгрөгийн хоолны мөнгийг давхардуулан олгосон. / жагсаалтаар хавсаргав./
- Хүнгийн хөх төр ХХК-аас 2017 оны 02-р сарын 14-нд худалдан авсан 100,8 мянган төгрөгийн бичиг хэргийн материалын үнийг 2 удаа шилжүүлсэн зэрэгт нийт 3601,2 мянган төгрөгийн зөрчил илрүүлснээс 845,2 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

ДҮГНЭЛТ: Цаашид төсвийн зарцуулалттай холбоотой дээрх дутагдлуудыг дахин давтахгүй байж, хичээллэж буй дугуйлангуудын орлогыг байгууллагын дансаар дамжуулан гүйлгээ хийж орлого зарлагыг бүртгэж байх нь зүйтэй гэж үзлээ.

2.32017 онд Хүүхэд харах үйлчилгээнд зориулсан115540,1 мянган төгрөгийг дараах байдалтай зарцуулжээ.

2016-2017 оны хичээлийн жилд аймгийн хэмжээнд 6 суманд 24 хүүхэд харагч 112 хүүхдийг хамруулан хүүхэд харах үйлчилгээг эрхлэн явуулсан байна. Энэ хугацаанд өөрсдийн хүсэлтээр 1 нэгж 3 иргэн, стандарт хуулийн хэрэгжилтийг хангаагүй 2 нэгж 5 иргэн захиргааны санаачилгаар үйл ажиллагааг нь 2017 оны 06 дугаар сарын 01-ээр хаажээ.

2016-2017 оны хичээлийн жилд хүүхэд харах үйлчилгээнд олгосон санхүүжилт, хүүхэд харагчийн тоогхүснэгтээр харуулбал:

№	Баянтэс	Идэр	Их-Уул		Тосонцэн гэл	Түдэвтэй	Улиастай
			Унагалдай	Цүнцээлэй			
1-сар	1345124	1318240	1977360	1977360	3376252	1977360	3414720
2-сар	1345124	1318240	1977360	1977360	3376252	1977360	3414720
3-сар	1345124	1318240	1977360	1977360	3376252	1977360	2276480
4-сар	1345124	1318240	1977360	1977360	3376252	1977360	2276480
5-сар	1345124	1318240	1977360	1977360	2058012	1977360	2026480
	6725620	6591200	9886800	9886800	15563020	9886800	13408880
нийт							71949120

2016-2017 оны хичээлийн жилд ажилласан хүүхэд харагчийн тоо

№	Баянтэс	Идэр	Их-уул		Тосонцэнгэл	Түдэвтэй	Улиастай
			Унагалдай	Цүнцээлэй			
1	2	2	3	3	5	3	6
2	2	2	3	3	5	2	6
3	2	2	3	3	5	3	4
4	2	2	3	3	4	3	4
5	2	2	3	3	3	3	4

2017-2018 оны хичээлийн жилд Баянтэс суманд 2 хүүхэд харагч 10 хүүхэдтэй 1 нэгж, Идэр суманд 2 хүүхэд харагчтай 10 хүүхэд 1 нэгж, Их-Уул суманд 5 хүүхэд харагч 25 хүүхэдтэй 2 нэгж, Тосонцэнгэл суманд 2 хүүхэд харагчтай 9 хүүхэд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нэг нэгж төв, Түдэвтэй суманд 3 хүүхэд харагчтай 15 хүүхэдтэй 1 нэгж нийт 6 нэгжийн 14 хүүхэд харагч үйл ажиллагаа явуулсан байна.

2017-2018 оны хичээлийн жилд олгосон санхүүжилт

№	Баянтэс	Идэр	Их-Уул		Тосонцэнгэл	Түдэвтэй	Нийт дүн
			Унагалдай	Цүнцээлэй			
9-сар	1415084	1318240	1647800	1647800	2058012	1977360	10,064,296
10-сар	1569821	1458910	2188365	1458910	2311218	2188365	11,175,589

11-сар	1569821	1458910	2188365	1458910	2311218	2188365	11,175,589
12-сар	1569821	1458910	2188365	1458910	2311218	2188365	11,175,589
Нийт	6124547	5694970	8212895	6024530	8991666	8542455	43,591,063

2017-2018 оны хичээлийн жилд ажилласан хүүхэд харагчийн тоо

Сар	Баянтэс	Идэр	Их-уул		Тосонцэнгэл	Түдэвтэй
			Унагалдай	Цүнцээлэй		
9	2	2	3	3	3	3
10	2	2	3	2	3	3
11	2	2	3	2	3	3
12	2	2	3	2	3	3

Тайланд онд Хүүхэд харах үйлчилгээнд нийт 115540,1 мянган төгрөгийг олгожээ.

Хүүхэд харах үйлчилгээнд олгосон санхүүжилтийг зориулалтын дагуу үнэн зөв зарцуулсан байна.

Аудитын явцад Тосонцэнгэл, Их-Уул сумдын хүүхэд харах үйлчилгээний нэгжтэй газар дээр нь очиж танилцахад Их-Уул сумын Унагалдай бүлэг 3 хүүхэд харагч 8 хүүхэдтэй үйл ажиллагаа явуулж байна.



Цүнцээлэй бүлэг нь 2 хүүхэд харагч 10 хүүхэдтэй байхаас 9 хүүхэд хүүхэд харах үйлчилгээнд хамрагдаж 1 хүүхэд өвчтэй хэвийн үйл ажиллагаа явагдаж байлаа.



2.4. ГБХЗХГ- нь тайланд онд Гэр бүл, хүүхэд, залуучуудын, хөгжлийн газар ТББ, НҮБ-ын хүүхдийн сан, ХНХЯ-наас төсөл хөтөлбөрөөр нийт 118200,0 санхүүжилтийг хүлээн авч, зориулалтын дагуу зарцуулжээ.

Төсөл хөтөлбөрийн санхүүжилт нь хамтарсан багийн сургалт, Баруун бүсийн ажилтнуудыг мэргэшүүлэх чадавхжуулах сургалт, нөлөөллийн ажилтныг сургах суртачилгаа явуулах сургалт болон залуучуудын хөгжлийн төвийн ажилтны цалин үйл ажиллагааны зардалд зориулагдсан байна.

Сургалтыг цаг хугацаанд нь үр дүнтэй зохион байгуулсан бөгөөд зарцуулалттай холбоотой зөрчил, илрээгүй боловч, Сургалт семинарын үр дүн, үр нөлөөг нэгтгэж дүгнэдэггүй байна.

ДҮГНЭЛТ: Төсөл хөтөлбөрөөр хийгдсэн сургалтууд заасан хугацаанд зохион байгуулагддаг хэдий ч, үр дүнг нь хэлэлцдэггүй байна.

Бүлэг 3. Сахиулын цалинг Монгол улсын Засгийн газрын 2007 оны 12 сарын 26 - ны өдрийн 354 тоот тогтоолын дагуу зөв тогтоогоогүй байна.

2017 онд Тус байгууллага нь үндсэн 11 орон тоотой үйл ажиллагаа явуулсан байна.

Тайлант онд батлагдсан дээрх орон тооноос гадна НҮБ-ийн хүн амын сан, Засгийн газраас хэрэгжүүлсэн төслийн хүрээнд Залуучуудын хөгжлийн төвийн 3 ажилтан, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газраас хүүхэд хамгааллын гэрээтийн 1 орон тоотой бүгд 15 орон тоогоор үйл ажиллагаа явуулжээ.

Тайланд онд шинээр орон тоо нэмээгүй, ажлаас чөлөөлөгдсөн бөгөөд халагдсан орон тоо байхгүй байна.

Аудитын явцад цалин тогтоолтыг шалган үзэхэд Сахиулын цалинг Монгол улсын Засгийн газрын 2007 оны 12 сарын 26-ны өдрийн 354 тоот тогтоолыг зөрчин ТҮ-3-5 шатлалаар тогтоосон зөрчил илэрлээ.

Ингэж тогтоосон шалтгааныг тодруулахад сантехник, цахилгааны ажлыг давхар гүйцэтгэдэг гэсэн тайлбарыг өгч байна.

ДҮГНЭЛТ: Цаашид сахиулын цалинг Монгол улсын Засгийн газрын 2007 оны 12 сарын 26-ны өдрийн 354 тоот тогтоолын дагуузөв тогтоож хавсарч байгаа ажилд хөдөлмөрийн хуулийн дагуу хавсран ажилласан нэмэгдлийг олгох нь зүйтэй байна гэж үзлээ.

Бүлэг 4. Хөрөнгийн хадгалалт хамгаалалт, ашиглалт, эмх цэгц сайн дутагдсан хөрөнгө байхгүй бөгөөд тооллогын үр дүнг хэлэлцдэггүй байна.

Аудитын явцад хөрөнгийн худалдан авалт, ашиглалт, хадгалалт, хамгаалалтын байдалтай газар дээр нь танилцаж, хэсэгчилсэн тооллого хийлээ.

Хэсэгчилсэн тооллогоор хөрөнгийн дутагдал гараагүй болно.

Байгууллагын тавилга эд хогшил, тоног төхөөрөмжүүдийг эзэмшиж буй ажилтнууд дээр карталж эзэмшүүлсэн байна.

2017 онд Дэлхийн зөн олон улсын байгууллагаас 84,800 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, Нэгдсэн Үндэсний Байгууллагын хүн амын сангийн хөрөнгө оруулалтаар 4,200 мянган төгрөгийн тавилга хэрэгсэл, 2,100 мянган төгрөгийн номын фонд хандивласныг орлогод бүрэн тусгаж, ашиглаж байна.

Төсөл хөтөлбөр, хөрөнгө оруулалтаар хандивласан хөрөнгүүд орчин үеийн шаардлагад нийцсэн, хэрэгцээ шаардлагыг хангасан хөрөнгүүд нийлүүлэгджээ.

Нийлүүлэгдсэн хөрөнгүүдийг байгууллагын үйл ажиллагаа, болон хүүхэд залуучуудын чөлөөт цагаа үр дүнтэй өнгөрөөх танхим тохижуулах, тэдний мэдлэг чадварыг дээшлүүлэх ба, сургалт суртчилгаа, семинар зохион байгуулахад үр дүнтэй ашиглаж байна.

Тус байгууллагын бүртгэлд байгаа боловч, анхны өртгөөрөө элэгдэлээ нөхсөн, цаашид ашиглах боломжгүй 53 нэр төрлийн 8425,4 мянган төгрөгийн хөрөнгө байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.УЛАМБАЯР

ЗӨВЛӨМЖ

Завхан аймгийн Гэр, бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга Г. Мягмарсүрэнд

Завхан амгийн Гэр, бүл, хүүхэд залуучуудын газрын 2017 оны үйлжиллагааны үр дүндхийгдсэн аудитын дүн, дүгнэлтэдүндэслэндараах зөвлөмжийгөгчбайна.

1. Үйл ажилгааны төлөвлөгөөг боловсруулахдаа гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжилтэй холбогдох хуулинд заасан үүрэг, оролцоог үндэслэн, хэрэгжих боломжтой, утга давхардахгүй, үр нөлөөтэй ажил үйлчилгээг тусгах.
2. Дугуйланд суралцагчдын сургалтын төлбөрийн орлого түүний зарцуулалтыг бүртгэлд тусгаж байх, автомашины шатахуун зарцуулалтын хэтрэлт, хэмнэлтийг тооцож, жолоочийн тооцоог бүрэн хийх тооллогын үр дүнг удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэж байх.
3. Байгууллагын бүртгэлд байгаа бөгөөд цаашид ашиглах боломжгүй, анхны өртгөөрөө элдэгдлээ нөхсөн хөрөнгийг холбогдох газарт хүргүүлж, шийдвэр гаргуулж, актлах.
4. Сахиулын цалинг Монгол улсын Засгийн газрын 2007 оны 12 сарын 26-ны өдрийн 354 тоот тогтоолын дагуу зөв тогтоож, хавсран ажилласан нэмэгдлийг хавсарч байгаа албан тушаалын тохирох сүлжээгээр нь олгох.
5. Аудитаар төсвийн зарцуулалттай холбоотой илэрсэн алдааг таслан зогсоож, төлбөрийн актыг бүрэн барагдуулж, зөвлөмжийн биелэлтийг, нотлох баримтын хамт 2018 оны 11 сарын 01-ний дотор тоотоор ирүүлэх.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.УЛАМБАЯР